

**ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ, ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ СУРГУУЛЬ**

Боловсролд тэгш хамруулах, хүртээмжтэй байх нь ТХЗ 4-ийн үндсэн зорилт бөгөөд Монгол Улс уг зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлах бодлого, стратегийг үндэсний хөгжлийн бодлогодоо тодорхойлон хэрэгжүүлж байна. Тухайлбал, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2030 он гэхэд хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэл хийхээр зорьж байна. *Тэгш, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй сургууль нь “бүх суралцагчийн боловсролын үйл ажиллагаан дахь тэгш хамралт, оролцоог хангасан, аливаа ялгаварлан гадуурхалтгүй, сурч, хөгжихөд таатай, ээлтэй, үнэт зүйлс, соёлыг бий болгосон орчинд ялгаатай хэрэгцээндээ нийцүүлсэн боловсролын үйлчилгээг авах боломжийг хангасан байх” [...]* тухай ойлголт юм. Суралцагч бүр хүлээн зөвшөөрөгддөг, хүндлэгддэг, үнэлэгддэг гэдгээ мэдрэх боломж олгосон тэгш хүртээмжтэй, эрүүл аюулгүй орчинд бага наснаасаа эхлэн чанартай боловсролыг эзэмшиж чадвал нийгэмд тулгарч буй цаашдын асуудал багасаж, олон салбарын тэгш бус байдал арилна.

Манай улс тэгш хамрах боловсрол, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй болон бусад ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн боловсролд анхаарал тавьж, сүүлийн жилүүдэд бодлого, эрх зүйн хувьд цогц байдлаар хандаж байна. Суралцагчийг аливаа хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлт, үл хайхрах байдал, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор хүүхэд хамгааллын бодлого, сургуулийн орчны аюулгүй байдлын стандарт, сургуулийн орчинд хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардагдах эрх зүйн орчин бүрдүүлэхэд тодорхой ахиц гарсан. Сургуулийн өмнөх боловсрол олгохтой холбоотой нүүдлийн гэр цэцэрлэг, ээлжийн бүлэг, явуулын багш, ээлжийн багш, хувилбарт сургалтын үйлчилгээ бий болгосон ололттой тал байна. Мөн сургууль дээр сурагчдад эрүүл, шим тэжээлт хоол хүнсээр үйлчлэхийн тулд үдийн цайны нэг хүүхдэд ногдох санхүүжилт 2016 онд 600 төгрөг байсныг 2022 онд 1.500 төгрөг болгож, “Үдийн хоол” болгон өргөжүүлсэн.

КОВИД-19 цар тахлын үед нийт 4485 теле хичээлийг бэлтгэж, орон даяар 16 телевизийн суваг болон [econtent.edu.mn](http://econtent.edu.mn) сайтаар дамжуулан суралцагчдад хүргэсний дотор үндэсний цөөнхийн суралцагчдад зориулан тэдний эх хэл дээр орчуулсан, бэлтгэсэн хичээлүүд ч орж байна. Мөн цахим контентын нэгдсэн сан бүрдүүлэх [MEDLE.mn](http://MEDLE.mn) платформ хөгжүүлэн ашигласны зэрэгцээ алслагдсан сум, багийн сургуулийн болон боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдэд хэвлэмэл болон тохируулгат материал боловсруулан хүргэж, зайнаас суралцах боломж олгосон байна.

**Монгол Улсын санаа зовж буй гол асуудал**

Монгол улсад хамран сургалт өндөр байгаа боловч хүүхэд бүр өөрт тохирсон чанартай боловсролын үйлчилгээг зохих түвшинд авч чадахгүй, малчин, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг ядуу бүлгийнхний хүүхдүүд боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй үлдсээр байна. 2021-2022 оны хичээлийн жилд амьдралын гачигдал, хөгжлийн бэрхшээл, өвчин, ажил эрхлэх, сурах дургүй байх зэргээс шалтгаалан 6-14 насны сургуулиас гадна байгаа буюу сургуульд огт ороогүй 967, сургуульд ороод завсардсан 204 хүүхэд байна [2]. Хичээл, сургалтын үйл ажиллагааг зайнаас зохион байгуулах хугацаанд теле хичээлийг тасралтгүй үзэх боломж хүүхэд бүрд харилцан адилгүй, тэдний онцлог хэрэгцээнээс хамаарсан хичээл сургалтууд явагдах боломж хязгаарлагдмал байсан нь

хичээл, сурлагын хоцрогдол үүсгэж, хүүхдийн нийгэмшихүйн чадвар, суралцахуйн чанарт сөрөг нөлөө үзүүлсэн нь судалгаагаар илэрсэн юм.

- **Хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээл:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын сурах эрх, тэгш хамран сургах боловсролын оролцоог хангах эрх зүйн орчин эрс сайжирч, нийгмийн хандлага өөрчлөгдөж байгаа ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамран сургалт харилцан адилгүй, бодлого, журмын хэрэгжилт жигдрээгүй байна. Цар тахлын үед, 2021-2022 оны судалгаагаар 2-16 насны 1869 хүүхэд хөгжлийн бэрхшээл болон өвчин эрүүл мэндийн шалтгаанаар сургуульд сурч чадахгүй завсардсан байна. Суралцагчдын хөгжлийн хоцрогдол болон бэрхшээлийн эрт илрүүлэлт хангалттай бус байгаагаас тэдэнд шаардлагатай дэмжлэгийг оройтуулж байна.
- **Жендер:** Сургууль завсардаж болзошгүй эрсдэлд байгаа бага боловсролын 965 сурагчийн 67 хувь нь эрэгтэй, суурь боловсролын 825 сурагчийн 630 буюу 76 хувь нь эрэгтэй, бүрэн дунд боловсролын 141 сурагчийн 113 буюу 80% нь эрэгтэй байна. Хөвгүүдийнхээ боловсролд бага анхаарч, бүрэн дунд боловсролоос завсардуулан, ур чадвар бага шаардах ажилд эрт оруулах хандлага амьжиргааны түвшин доогуур, ялангуяа, малчин өрхүүдэд түгээмэл байна. Үүнд үндэстний цөөнхийн хүүхдүүд ч мөн хамаарна. Мөн КОВИД-19 хөл хорионы үед охидын жирэмслэлтийн тоо, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо нэмэгдсэн байна.
- **Ядуурлын өсөлт ба суралцахуй дахь нийгэм, эдийн засгийн ялгаа:** Цар тахлын үеийн нийгмийн хамгааллын бодлогын үр дүнд өрхийн орлого буураагүй боловч нийгэм, эдийн засгийн ялгаатай гэр бүлд буй хүүхдийн боловсролын ялгаа илүү их болсон гэж үзэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, ядуу өрхийн хүүхдүүд боловсролын тасалдал, суралцахуйн хоцрогдолд илүү өртсөн байх эрсэлдтэй байна.
- **Алслагдсан болон хөдөө орон нутгийн хүүхдүүд.** Малчин өрхийн хүүхдийн боловсролтой холбоотой тэдний сургуульд бэлтгэгдсэн байдал болон сургууль завсардалт тулгамдсан асуудал болж байна. Цар тахлын үед теле хичээлийн хүртээмж хамгийн бага хүрсэн сурагчид нь малчин, төв сууринаас алслагдсан, орлогын түвшин доогуур болон эцэг эхийн анхаарал халамж сул өрхийн хүүхдүүд байна.
- **Үндэсний цөөнхийн хүүхэд:** Хичээлийн хэл (ихэвчлэн үндэсний, албан ёсны хэл) нь суралцагчийн гэрт хэрэглэж буй хэлээс ялгаатай үед үндэсний цөөнхийн хүүхдийн хэл яриа, хөгжлийн чадвар бусад хүүхдүүдээс хоцрох шалтгаан болдог.
- **Сургуулийн хоол үйлдвэрлэл, эрүүл мэнд:** Сурагчид шим тэжээлтэй сургуулийн хоолоор хангагдахтай болон сургалтын байгууллагын дэд бүтэц, тоног төхөөрөмж, төвлөрсөн усан хангамж, ариун цэврийн байгууламжтай холбоотой асуудлууд, ялангуяа хөдөө орон нутагт бүрэн шийдэгдэж чадаагүй байна. 357 сургууль буюу нийт сургуулийн 52.3%, 220 цэцэрлэг буюу 22.9%, 242 дотуур байр буюу 45.2% гаднаа нүхэн жорлонтой байна.
- **Аюулгүй сургууль:** Боловсролын салбарт хүүхэд хамгааллын бодлого, сургуулийн орчны аюулгүй байдлын стандарт, сургуулийн орчинд хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт нэгж байгууллагын түвшинд хангалтгүй байна. Эрсдэлийн үнэлгээгээр ерөнхий боловсролын 177 сургууль буюу 31% нь дунд эрсдэлтэй, 64 сургууль буюу 11.4% нь их эрсдэлтэй гэж үнэлэгдсэн. Улаанбаатар хотын 9 дүүргийн ЕБС-ийн 11-16 насны 1,236 суралцагчийг хамруулан хийсэн судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдагсдын 37.9 хувь нь ямар нэг байдлаар дээрэлхүүлж, доромжлуулсан 40.7 хувь нь бусад хүүхдийг зодуулж дээрэлхүүлж байхыг харсан бол 80 гаруй хувь нь дарамтлуулж, шоовдорлуулсан, ямар нэг асуудал гарахад хаана, хэнд хандахаа мэддэггүй гэж хариулсан байна. Хөгжлийн

бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн орчинд саадгүй нэвтрэх, аюулгүй зорчих боломжийг бүрдүүлэхийг чухалчлан сургуулиуд дэд бүтцийн өөрчлөлтүүдийг хийж эхэлсэн боловч тоон үзүүлэлтийн талаарх мэдээлэл хангалттай бус байна.

### Шийдвэрлэх арга зам

#### Тэгш, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй сургуулийн төлөө:

Монгол Улс цар тахлын дараа бүх сургуулиа амжилттай нээж, суралцагчид сургуульдаа буцаж ирсэн. Гэвч тэд суралцахуйн алдагдалд орж, сургуулиасаа, ангийн хамт олноосоо олж авдаг нийгмийн харилцаа холбоогоо сэргээж чадаагүй байна. Цар тахлын өмнө ч янз бүрийн шалтгааны улмаас суралцах боломжгүй байсан эмзэг бүлгийн хүүхдүүд, ялангуяа сургууль удаан хугацаагаар хаагдсаны дараа сургуульд ирэх нь бүр ч хэцүү байх болно. Энэ нь эмзэг бүлгийн хүүхдүүдийг эргэж ирэх, суралцах боломжийг нь хангахын тулд тусгай арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

Мөн сургууль бүр суралцахаар ирж буй хүүхэд бүрт үйлчилэхэд бэлэн, нийгэм сэтгэл зүйн болон материаллаг орчны хувьд эрүүл, аюулгүй байж, суралцагчдынхаа давуу тал болон хэрэгцээ шаардлагад тохируулан зохистой байдлаар хариу үйлдэл үзүүлэх боломжтойгоор хувьсан өөрчлөгдөх цаг үе ирсэн байна.

Үүний тулд:

- **Хэн, хаана, хамгийн их хоцорсныг тодорхойлох:** Цар тахлын нөлөөнд хамгийн их өртсөн сургуулийн гадна үлдсэн, хамгийн их хоцрогдсон эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын эмзэг байдал, суралцахуйн алдагдлыг тодорхойлох;
- **Оношлох, үнэлэх:** Суралцах алдагдлыг тодорхойлох, хэмжих, сургалтын ахиц дэвшлийг илрүүлэх болон нэгтгэн дүгнэх зорилгоор суралцагчийн үнэлгээний хэрэгслийг боловсруулах ашиглах; илүү нээлттэй, уян хатан үнэлгээ, баталгаажуулалтын бүтэц, тогтолцоог хөгжүүлэх;
- **Тохируулгат сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх:** Ялгаатай болон тусгай хэрэгцээтэй суралцагчдад зориулсан суралцахуйн алдагдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилго бүхий тэгш хамран сургах, уян хатан, тохируулгат сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх;
- **Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг нэвтрүүлэх:**
  - Сургуулийн болон орон нутгийн хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд суралцагч, багш, ажилтнууд, эцэг эх, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, нөөцийн үр ашигтай ашиглах, ариун цэврийн байгууламж, эрүүл хоол хүнс, ногоон байгууламж зэргийг бий болгох замаар суралцахуйн орчныг хувирган өөрчлөх;
  - Суралцагчийг ойлгох, сэтгэл зүйн хямрал, гутрал, тогтворгүй байдлыг даван туулах, сурч, хөгжихөд нь нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх;
- **Хүний нөөцийг хөгжүүлэх:** Тэгш хамран сургах боловсролын талаар эцэг эх, асран хамгаалагч, олон нийт, ялангуяа боловсролын салбарын мэргэжилтнүүдийн ойлголт хандлагад анхаарлаа хандуулах, багшийг чадавхжуулах, багшид дэмжлэг үзүүлэх тогтолцоог хөгжүүлэх;

**Боловсролыг хувирган өөрчлөхөд тэгш байдал, хүртээмж, жендэр, эрүүл, аюулгүй байдлыг хангахын тулд:**

- Дижитал суралцахуйг оролцуулаад суралцагч өөртөө тохирсон хэлбэрээр боловсрол эзэмших арга замыг нээх, аль ч хэлбэрээр эзэмшсэн боловсролыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах;
- Боловсролын төсөв, төлөвлөгөөг ялгаварлан гадуурхалгүй, тэгш боломжоор хангасан, эмзэг бүлэгт чиглэсэн зорилтот стратегиар боловсруулж, хэрэгжүүлэх;
- Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэх;
- Тэгш хамрах боловсролын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур аргачлалыг тусгайлан боловсруулж, боловсролын албан ёсны мэдээллийн санд тэдгээртэй холбоотой өгөгдөл мэдээллийг цуглуулж, нотолгоонд суурилсан бодлого төлөвлөлтийг боловсруулах;
- Онцгой байдлын үед боловсролын үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй олгох бэлэн байдлын цогц төлөвлөгөө боловсруулах;
- Мэдээлэл, харилцаа, холбооны технологийг ашиглах, цахим, зайн сургалт хөтлөх, цахим бичиг үсгийн боловсрол болон цахим орчинд аюулгүй байдлаа бүрдүүлэхэд төрийн, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа түншлэл, оролцоог хангах;

**Эх сурвалж**

- [1] БСШУЯ, ЮНИСЕФ. (2020). Тэгш хамран сургах боловсролын нэр томъёо, арга зүйн зөвлөмж.
- [2] БМТТ. 2021-2020 оны хичээлийн жилийн статистик.
- [3] БШУЯ, ЮНЕСКО. (2022). Монгол улсын "Тогтвортой хөгжлийн зорилго-4"-ийн хэрэгжилтийн ахиц дэвшлийн тойм үнэлгээ (2016-2021).
- [4] БШУЯ, БСҮХ (2021). Сургууль завсардаж болзошгүй хүүхдийг илрүүлэх судалгааны тайлан.
- [5] БШУЯ, НҮБ-ын Хүүхдийн Сан, МУИС. (2020). Хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн асуудал, эрсдэлийг илрүүлэх судалгаа.
- [6] БШУЯ, ЮНЕСКО. (2022). Монгол улсын "Тогтвортой хөгжлийн зорилго-4"-ийн хэрэгжилтийн ахиц дэвшлийн тойм үнэлгээ (2016-2021)
- [7] ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мэдээлэл.
- [8] БШУЯ (2019). ЕБС-ийн орчны эрсдлийн үнэлгээ.
- [9] Хүүхдийг ивээх сан (2017). Өсвөр үеийнхний дуу хоолой.

**Чиглүүлэх асуулт**

.....	Зорилтот бүлэг 1 Залуучуудын төлөөлөл	Зорилтот бүлэг 2 Сургууль, багш, эцэг эх	Зорилтот бүлэг 3 Иргэний нийгмийн байгууллага	Зорилтот бүлэг 5 Хэвлэл мэдээлэл
Суралцахуйн хоцрогдол: Хамгийн их хоцрогдсон, дижитал	1. Хамгийн их хоцрогдсон, дижитал хуваагдалд өртсөн суралцагчдад ямар дэмжлэгийг хамгийн түрүүнд үзүүлэх хэрэгтэй вэ? Бодлогын бодит шийдлүүд юу вэ? 2. Боловсролын үйлчилгээг тасралтгүй авч чадаагүй нийгмийн тодорхой бүлэгт ашигласан ямар сайн туршлага байна вэ?			

## ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА ЯРИЛЦЪЯ

хуваагдалд өртсөн бүлэг	3. Сурлагын хоцрогдлыг нөхөж арилгах бодлогын шийдлүүдийг хэрэгжүүлэхийн тулд бид хамгийн түрүүнд юу хийх шаардлагатай вэ?
Сургуулийг хувирган өөрчлөх нь	<ol style="list-style-type: none"><li>1. Сургуулийг илүү нээлттэй, хэнийг ч орхилгүй суралцах боломжийг хангасан, эрүүл, аюулгүй байхаар хувирган өөрчилөхийн тулд бодлогын тэргүүлэх чиглэл юу байж болох вэ?</li><li>2. Бид энэ чиглэлээр юуг хийж чадсан бэ? Юу хийж чадаагүй вэ?</li><li>3. Бодлогын шийдлүүдийг хэрэгжүүлэх хамгийн чухал арга хэмжээнүүд юу вэ?</li></ol>